



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/2014

Мандалговь

Г Шатахууны нөөц бүрдүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1.1 дэх заалт, Монгол Улсын сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, 4 дүгээр зүйлийн 4.10, Засаг даргын зөвлөлийн 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын хурлын 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 3 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

Нэг. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах, төрийн үйлчилгээг малчид иргэдэд шуурхай хүргэх, цаашид мал аж ахуйн авалжилт хүндэрч болзошгүй тул малдчын отор нүүдэл хийх гарцыг тодорхойлох ажлын хэсгийн унааны шатахуун, бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд зориулж 2 тонн шатахууны нөөцийг Онцгой байдлын газрын мэдэлд бүрдүүлсүгэй.

Хоёр. Шатахууны нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай 3,500,000.00 /гурван сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /О.Чулуунбат/ нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Нөөц шатахууныг онцгой комиссын хяналт дор үр ашигтай зарцуулж тайланг зохих журмын дагуу гаргаж ирүүлэхийг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч /хурандаа Я.Алтанхундага/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200772